



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/334

Есөнбулаг сум

“Жангар фестиваль-2026” залуучуудын
арга хэмжээг зохион байгуулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүй, эрүүл мэнд, цус ойртолт ба угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, үнэт зүйл амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, нийгэм дэх тэдний оролцоог дэмжих, хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгын хүрээнд “Жангар фестиваль” залуучуудын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөө гарган батлуулж, үр дүнтэй удирдан зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (М.Насанбат)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 09 -ны өдрийн 0334 дүгээр
захирамжийн хавсралт

Нэг. ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга:	М.Насанбат	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүдэд:	Д.Баяраа	(Аймгийн Засаг даргын хэвлэлийн албаны дарга)
	Я.Жаргалцэцэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
	Л.Хаш-Эрдэнэ	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
	Н.Эрдэнэ-Очир	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрхзүйн хэлтсийн дарга)
	Д.Буянхишиг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтсийн дарга)
	Ж.Амгаланбаатар	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
	Н.Шинэбаяр	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)
	О.Баатарчулуун	(Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга)
	Д.Энхцэцэг	(Аймгийн Боловсролын газрын дарга)
	Д.Бүрэнбаатар	(Аймгийн Цагдаагийн газрын дарга)
	Ж.Уранчимэг	(Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга)
	Д.Батмагнай	(Аймгийн Байгаль орчны газрын дарга)
	Ц.Лувсанжамц	(Аймгийн Онцгой байдлын газрын дарга)
	Б.Алтайбаатар	(Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга)
	Н.Мэндсайхан	(Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга)
	Ё.Нарангарав	(“Инноваци, судалгаа бизнес хөгжлийн төв”-ийн захирал)
	Ш.Насан	(Аймгийн “Жангар” музейн захирал)
	Я.Одгэрэл	(Аймгийн “Жангар” нийтийн номын сангийн захирал)
	Э.Отгонбаатар	(Ардын дуу бүжгийн “Алтай” чуулгын дарга)
	Х.Ундармаа	(Аймгийн Насан туршийн

	И.Гантулга	суралцахуйн төвийн захирал) (Аймгийн "Нийтлэг үйлчилгээ" Улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга)
	Э.Энхболд	("Ундрага Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал)
	Т.Лодой	(Алтай хотын тохижилт, үйлчилгээний газрын дарга) Сумын Засаг дарга нар Аймгийн Засаг даргын Тамгын газрын гэрээт хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдлагууд)
Нарийн бичгийн дарга:	Т.Баярзул	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын бодлого хариуцсан мэргэжилтэн)

Хариуцан хийх ажлын чиг үүрэг:

Ерөнхий удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах, нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;

Хоёр.ЁСЛОЛ ХҮНДЭТГЭЛ ХАРИУЦСАН ДЭД АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга:	Я.Жаргалцэцэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
Гишүүд:	Б.Мөнхжаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад харилцаа, орон нутгийн удирдлага хариуцсан мэргэжилтэн)
	Л.Нямбаяр	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Шийдвэрийн хэрэгжилт, өргөдөл гомдол, шагнал хариуцсан мэргэжилтэн)
	Ц.Ганчимэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрхзүйн хэлтсийн Захиргааны хэм хэмжээний акт, гэрээ, сумдын эрх зүйн акт хариуцсан мэргэжилтэн)
	З.Жаргалтуяа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн)
	Н.Бадамгарав	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтэн)
	О.Алтанзул	(Аймгийн Засаг даргын туслах)

Нарийн бичгийн дарга:	Д.Хандсүрэн	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав)
	И.Гантулга	("Нийтлэг үйлчилгээ" Улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга)
	Ч.Няндаг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хариуцан хийх ажлын чиг үүрэг:

Хүндэт зочдын нэрс гаргах, урилга түгээх, хүндэтгэлийн өргөөний үйлчилгээ, хоол хүнс, идээ, угтах үдэх үйл ажиллагааг хариуцах;

Гурав. ФЕСТИВАЛИЙН ОРОЛЦОГЧ ЗАЛУУЧУУДЫГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ ДЭД АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга:	С.Цагаанбаатар	(Аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)
Гишүүд:	П.Хулан	(Аймгийн Төрийн архивын хэлтсийн дарга)
	Я.Одгэрэл	(Аймгийн "Жангар" Нийтийн номын сангийн захирал)
	Ш.Насан	(Аймгийн "Жангар" музейн захирал)
	Х.Ундармаа	(Аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн захирал)
Нарийн бичгийн дарга:	Б.Алтайбаатар	Сумын Засаг дарга нар (Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга)

Хариуцан хийх ажлын чиг үүрэг:

Хамтран зохион байгуулагчид болон оролцогчидтой холбоо тогтоож, оролцогч залуучуудын нэрс гаргах, урилга түгээх, угтах, үдэх үйл ажиллагаа, гэр хуваарилалт хийх;

Оролцогч залуучуудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж хөтөлбөрийн дагуу хамрагдалтыг ханган ажиллах, өртөөчилсөн сургалтын хөтөлбөр гаргаж оролцоог ханган ажиллах;

Дөрөв. ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ДЭД АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга:	Ж.Амгаланбаатар	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Гишүүд:	Ж.Очир	(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга:	Д.Энхцэцэг	(Аймгийн Боловсролын газрын дарга)

Хариуцан хийх чиг үүрэг:

Фестивалын хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, аж ахуй нэгжүүдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, эрүүл ахуйн шаардлага ханган ажиллах;

Тав. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ ХАРИУЦСАН ДЭД АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга:	Д.Буянхишиг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтсийн дарга)
Гишүүд:	Э.Отгонбаатар	(Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын дарга)
	Ж.Уранчимэг	(Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга)
	Ц.Лувсанжамц	(Аймгийн Онцгой байдлын газрын дарга)
	Б.Жаргалсайхан	(Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын Ерөнхий найруулагч)
Нарийн бичгийн дарга:	С.Сувдмаа	(Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын туслах найруулагч)

Хариуцан хийх ажлын чиг үүрэг:

Фестивалийн нээлтийн үйл ажиллагааны хөтөлбөр, зохион байгуулалт, 2 өдрийн оройн арга хэмжээ, спортын тэмцээн, уралдааны хөтөлбөр, хөтлөгч, урлагийн үзүүлбэр, салютын үзүүлбэр, галын наадам, хөгжим техник хэрэгсэл, уран бүтээлчдийг бүрэн хариуцаж, зохион байгуулалтыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх;

Зургаа. ХЭВ ЖУРАМ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ДЭД АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга:	Н.Эрдэнэ-Очир	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрхзүйн хэлтсийн дарга)
Гишүүд:	О.Баатарчулуун	(Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга)
	Д.Бүрэнбаатар	(Аймгийн Цагдаагийн газрын дарга)
	Ц.Лувсанжамц	(Аймгийн Онцгой байдлын газрын дарга)
	Н.Мэндсайхан	(Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Х.Лхагважав	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрхзүйн хэлтсийн мэргэжилтэн)

Хариуцан хийх ажлын чиг үүрэг:

Фестивальд оролцогчдын аюулгүй байдал, хэв журмыг сахиулж, эрүүл мэнд болон бусад шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх;

**Долоо. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН
ДЭД АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн дарга:	Д.Баяраа	(Аймгийн Засаг даргын хэвлэлийн албаны дарга)
Гишүүд:		Аймгийн Засаг даргын Тамгын газрын гэрээт хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдлагууд)
Нарийн бичгийн дарга:	Ё.Нарангарав	("Инноваци, судалгаа бизнес төв"-ийн захирал)

Хариуцан хийх ажлын чиг үүрэг:

Фестивалийн урилга, постер, анонсны эх бэлтгэл, кэмпиин тохижолтын зураглал, маркетинг, сурталчилгааг хариуцах;

**Найм. КЭМПИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТОХИЖОЛТ,
АЖ АХУЙ ХАРИУЦСАН ДЭД АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн дарга:	Д.Батмагнай	(Аймгийн Байгаль орчны газрын дарга)
Гишүүд:	Н.Шинэбаяр	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)
	А.Алтанхуяг	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Б.Пүрэвбаатар	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл, мэдээлэл технологи, цахим засаглал сүлжээний аюулгүй байдлын бодлого хариуцсан мэргэжилтэн)
	Л.Жамбалсүрэн	(Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн захирагч)
	И.Гантулга	("Нийтлэг үйлчилгээ" улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга)
	Э.Энхболд	("Ундрага Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал)
	Х.Биндэрьяа	("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн ерөнхий инженер)
	Г.Даржаа	(Хөхморьт сумын Засаг дарга)
Нарийн бичгийн дарга:	Т.Лодой	(Алтай хотын тохижилт, үйлчилгээний газрын дарга)

Хариуцан хийх ажлын чиг үүрэг:

Кэмпиийг зураглалын дагуу тохижуулж, тайз дэлгэц, ариун цэврийн байгууламж болон орчны цэвэрлэгээ үйлчилгээ, фестивалийн дараах цэвэрлэгээг хариуцан ажиллах;

Найм. ТӨСӨВ САНХҮҮ ХАРИУЦСАН ДЭД АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга:	Л.Хаш-Эрдэнэ	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Гишүүд:	Н.Наранцэцэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)
	Д.Бямба-Очир	(Аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын нягтлан бодогч)
Нарийн бичгийн дарга:	Ү.Отгонзаяа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн Төрийн сангийн төлбөр тооцооны мэргэжилтэн)

Хариуцан хийх чиг үүрэг:

Фестивалийн төсвийг нэгтгэн гаргаж, зарцуулалт, тайлагналтыг хариуцан ажиллах;

_ оОо _